


**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД ХИЛИЙН БООМТЫГ ТӨМӨР ЗАМААР ХОЛБОХ”
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ХББНУХШХ-ИЙН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ПУНСАНЦОГВОО

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ПҮРЭВЖАРГАЛ

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Э.САНСАРБАЯР

Улаанбаатар хот

2025 он



**“ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД ХИЛИЙН
БООМТЫГ ТӨМӨР ЗАМААР ХОЛБОХ” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ

ТАНИЛЦУУЛГА..... 2

1.1 Төслийн товч танилцуулга 2

1.2 Төслийн төлөвлөлт 2

1.3 Төслийн үе шатны гүйцэтгэлийн талаарх танилцуулга..... 9

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

БИЕЛЭЛТ 14

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... 14

2.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт..... 15

2.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 15

2.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт 16

2.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт..... 17

2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт 18

2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 21

2.8 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт 21

Хавсралт зургийн жагсаалт

Хавсралт зураг 1. Зам талбайн тоосжилтыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

Хавсралт зураг 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хавсралт зураг 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хавсралт зураг 4. Үржил шимт хөрс хуулалт хадгалалт

Хавсралт зураг 5. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа, санамж анхааруулга

Хавсралт зураг 6. Техник, технологийн хяналтын инженерүүд ХАБЭА-н сургалт

Хавсралт зураг 7. Гал унтраах хор ажилчдын байранд байршуулсан

Хавсралт зураг 8. Бохир ус хуримтлуулах юмкостын газар дээрх тагны битүүлэл

Хавсралт зураг 9. Агаарын чанарын хэмжилт, дээжлэлтийн явц

Хавсралт зураг 10. Хөрсөн бүрхэвчийн хэмжилт, дээжлэлтийн явц

Хавсралт материалын жагсаалт

Хавсралт материал 1. Техник тоног төхөөрөмжийн бүртгэлийн жагсаалт

Хавсралт материал 2. Усны тоолуурын баталгаажуулсан гэрчилгээ

Хавсралт материал 3. Ус ашиглах дүгнэлт

Хавсралт материал 4. Ус ашиглах гэрээ

Хавсралт материал 5 . Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгэсэн тухай

Хавсралт материал 6. Аюултай хог хаягдлын сургалт

Хавсралт материал 7. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг онилгоонд хамруулсан баримт

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Товч танилцуулга.

Төслийн нэр:	“Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Тавантолгой төмөр зам” ХХК Улсын бүртгэлийн дугаар:9011773057 Регистерийн дугаар: 6375405
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Юнион бюлдинг А блок 7 давхарт, Утас: 88116530
Төслийн байршил:	“Гашуунсухайт-Ганц мод хилийн боомтыг төмөр замаар холбох” төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байна.

1.2 Төслийн төлөвлөлт.

Монгол Улсын Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг БНХАУ-ын Ганцмод-Ваншүйчоуань чиглэлийн төмөр замтай холбоно.

Энэхүү төслийн хүрээнд хийгдэх үндсэн ажлуудад стандарт царигын өртөө, өргөн болон стандарт царигийн хил, гаалийн хяналтын талбай, хил дамнасан гүүр, шинээр баригдах шилжүүлэн ачих талбай зэрэг үндсэн байгууламжууд багтана.

“Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр замын төсөл нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын үргэлжлэл бөгөөд нийт 7 багц ажлаас бүрдэнэ. Үүнд :

- Багц 1. Дээд, доод бүтэц
- Багц 2. Урт гүүр (эстакад)
- Багц 3. Эрчим хүч;
- Багц 4. Барилга байгууламж
- Багц 5 Холбоо дохиолол
- Багц 6. Авто зам
- Багц 7. Гааль, хилийн хяналтын тоног төхөөрөмж


Энэхүү төслийн төмөр зам нь 1-р зэрэглэлийн, 1520 мм өргөн царигийн замын урт 10.801км, 1435 мм нарийн царигийн хос замын урт 8.697км, нийт гол замын урт 19,5 км, нийт гүүрний урт 9.35 км ба нийт трассын 48%-ийг эзэлж байна. Мөн техникийн үзүүлэлт, гадаргын хотгор гүдгэрээс шалтгаалан 11-12.5 м өндөр суурь бүтэцтэй төмөр зам баригдах нөхцөл үүссэн. Өргөн царигаар жилд 30 сая.тн, нарийн царигаар жилд 10 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай болно. Тус төмөр зам нь 3 гүүр, 28 ус зайлуулах хоолойтой байхаар төлөвлөгдсөн байна.

Төмөр зам. Өртөөний нарийн царигийн зам тавих ажил 10.801 км, өргөн царигийн зам тавих ажил 8.697 км байна. Өргөн царигийн 1/18 маркийн суман шилжүүлэг 2 ширхэг, нарийн царигийн 1/12 маркийн суман шилжүүлэг 12 ширхэг, 1/9 маркийн суман шилжүүлэг 2 ширхэг, өргөн, нарийн царигийн “Ромбо” огтлолцлын суман шилжүүлэг 1 байх бөгөөд чигжээс 51036 м³ байна. Одоо байгаа өргөн царигийн өртөөний зүүн талд нарийн царигийн өртөө шинээр барина.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт хэрэгжиж буй “Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох” төслийн 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”

Хүснэгт 1. Төслийн ерөнхий үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хүчин чадал
Нарийн царигийн зам тавих ажил	10.801 км
Өргөн царигийн зам тавих ажил	8.697 км
Нарийн цариг үндсэн талбайн өргөн	7м
Өргөн цариг үндсэн талбайн өргөн	7.6 м
Далангийн өндөр	11-12.5м
Нарийн царигийн гүүр	5.1 км
Өргөн царигийн гүүр	5.7 км
Гүүрний өндөр	11-12.5
Гүүр	2 жаазан гүүр
Ус нэвтрүүлэх хоолой	Нийт 26 ширхэг ус нэвтрүүлэх хоолой байна. Үүнээс дөрвөлжин хоолой 8, дугуй хоолой 18 байна.



Зураг 1.Төмөр замын ерөнхий төлөвлөлтийн зураг

Газар чөлөөлөлт.Өртөөний ойр орчмын газарзүйн байдал тэгш бөгөөд газрын гадарга дээрх зүйлийн гол ажил нь 35кв-ын өндөр хүчдэлийн шугам юм.

Газар шорооны ажил. Өртөөний дүүргэлтийн нийт хэмжээ 2 116 405 м³ орчим, ухмалын нийт хэмжээ 190,417 м³ бөгөөд буталмал чулуу 138 896 м³, FR ангиллын материал 484 273 м³, С ангилалын материал 1 493 236 м³ шаардлагатай.

Машин механизм, тоног төхөөрөмж. Одоо байгаа шилжүүлэн ачих машин механизм, тоног төхөөрөмж Өргөн царигийн шилжүүлэн ачих терминал нь тодорхой тооны чингэлэг шилжүүлэн ачих төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд энэ нь төмөр замаас авто машины тээвэрт чингэлэгийг шилжүүлэн ачих үйл ажиллагааг хариуцаж байна.

1.2.1 Төмөр замын техникийн үндсэн шаардлагуудын харьцуулалт, сонголт.

Төслийн техник эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгавар болон Монгол хятад улсын ойлголцлын санамж бичигтэй уялдуулан өргөн ба нарийн царигийн гол төмөр замын техникийн үндсэн шаардлагуудыг дараах байдлаар ТЭЗҮ-д сонгосон байна.

Төмөр замын зэрэглэл. Төмөр замын I зэрэглэлийнх байна.

Царигийн өргөн . Өргөн царигийн хэмжээ нь 1520 мм, нарийн царигийн хэмжээ нь 1435 мм байна.

Голын даралт буюу 1 голоос ирэх ачаалал. Төлөвлөсөн голын даралт нь ТавантолгойГашуунсухайт чиглэлийн төмөр зам, Ганцмод-Бугатын Ваньшуйчуань чиглэлийн төмөр замтай адил 25 тонн байна.

Гол замын тоо.Урьдчилан тооцоолсон хөдөлгөөний эрчимжилтийн тооцоогоор шинээр баригдах өргөн болон нарийн царигийн төмөр замууд нь нь нэг гол замтай байна.


Тахирын хамгийн бага радиус. Гол замын хамгийн бага тахирын радиус нь 1200м-ээс багагүй байх ба хүндрэлтэй нөхцөлд 800м-ээс багагүй байна.

Тооцоот хурд. Одоо байгаа Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ачааны галт тэрэгний хөдөлгөөний хурд нь ачаатай галт тэрэгний хувьд 80 км/ц, хоосон галт тэрэгний хувьд 100 км/ц байдаг. Энэхүү төсөлж буй шугамын ачааны галт тэрэгний хурд нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын хурдтай адил байна. Төмөр замын инженерчлэлийн нөхцөл болон төслийн ТЭЗҮ-ийн ажлын даалгавартай уялдуулан энэ төмөр замын тооцоолсон хурд 100-120км/ц байна.

1.2.2 Төлөвлөлтийн үзүүлэлт.

ТЭЗҮ-д сонгосон хувилбард хос шугамтай гүүрээр хил гарсны дараа өргөн, нарийн царигийн нэг шугамтай гүүрээр тус тус хойш үргэлжлэх бөгөөд өргөн царигийн зам нь Хувилбар-I-тэй адил байх ба хилийн авто зам, хилийн шалган нэвтрүүлэх талбайгаар дайран өнгөрсний дараа өргөн царигийн өртөөний замтай нийлж орно. Нарийн царигийн зам нь түр байрны хойгуур өргөн царигийн зам доогуур 2 түвшинд огтолцсоны дараа хилийн авто замыг дайран өнгөрнө. Одоогийн шилжүүлэн ачих терминалын зүүн талд шинээр баригдах нарийн царигийн хилийн шалган нэвтрүүлэх талбай байх бөгөөд одоогийн өргөн царигийн өртөөний зүүн талд шинээр нарийн царигийн өртөө баригдана. Нарийн царигийн өртөөг одоо байгаа шилжүүлэн ачих терминал болон зүтгүүрийн депотой холбох ба одоо байгаа зүтгүүрийн депогийн доторх замыг шинэчлэн барина. Тус хувилбард Гашуунсухайт дахь өргөн ба нарийн царигийн өртөө нь Ганцмод дахь өргөн ба нарийн царигийн өртөөний эсрэг талд байрлаж, өргөн ба нарийн царигийн замуудын шугам нь хоорондын замд 2 түвшинд огтлолцон өргөн ба нарийн царигийн гол шугамд адил бус хэвгийг ашиглана. Өргөн ба нарийн царигийн өртөөний ажлын хуваарлалтыг үндэслэвэл, өргөн царигийн систем нь экспортын ачаанд зориулах бөгөөд хүнд даацын галт тэрэгний чиглэлийн (Монгол Улсаас Хятад руу) хамгийн их хэвгий нь 6% байна. Нарийн царигийн өртөө нь импортын ачаанд зориулах бөгөөд хүнд даацын галт тэрэгний чиглэл (Хятад Улсаас Монгол руу) нь уруу чиглэлтэй, хамгийн их хэвгий нь 11% байна.

Өртөөний төлөвлөлт. Нарийн царигийн хяналтын талбайд хяналтын 2 замтай байхаар төлөвлөх ба тэдгээрийн ашигтай урт нь 1050м байна. Өргөн царигийн хилийн хяналтын талбайд хяналтын 2 зам (гол замыг оруулаад), тэдгээрийн ашигтай урт нь мөн 1700м байна. Нарийн царигийн хүлээн авах, явуулах паркт 3 зам байхаар төлөвлөх бөгөөд тэдгээрийн ашигтай урт нь 1050м-ийн шаардлагыг хангасан байх ба мөн 900м ашигтай урттай сэлгээний 1 замтай байхаар сонгосон байна. Өргөн царигийн хүлээн авах паркад өөрчлөлт оруулахгүй, хэвээр үлдээнэ. Шилжүүлэн ачих терминалд байгаа өргөн царигийн ачааны 1 замыг хуулан, шилжүүлж барих ба, нэмж нарийн царигийн ачааны 1 зам, нарийн царигийн ачааны нөөцийн 1 замыг тус тус барина, тэдгээрийн ашигтай урт нь 900м байна. Шинээр барих зүтгүүрийн гүйлтийн 1 замыг одоо байгаа зүтгүүрийн депотой холбож, одоо байгаа шатхуун буулгах замтай холбогдох шатхуун буулгах зам шинээр барьж, засвар үйлчилгээ, депод шатхуун буулгах шугам, засвар үйлчилгээний шугамыг төмөр замын шугам болгоно.



Зураг 2. Өртөөний зохион байгуулалтын бүрдүүвч зураг

1.2.3 Төмөр замын дээд бүтэц.

Тус чиглэлийн төмөр замын шугам 800 метрийн радиустай хоёр тахиртай ба одоо байгаа шилжүүлэн ачих терминал болон өргөн царигийн өртөөнд холбогдох зорилгоор төлөвлөсөн байна.

Тахир хоорондын хамгийн бага шулуун оруулгын хэмжээ Нарийн царигтай төмөр замын хувьд 120км/ц хурдтай байх үед шулуун шугамын хамгийн бага урт нь ерөнхийдөө 80м, хүнд нөхцөлд 50м байна. Өргөн болон нарийн царигийн шугамууд хоорондын замд зэрэгцэн байрлах үеийн тэнхлэг хоорондын зай 5.0 метр байна.

1.2.4 Замын доод бүтэц.

Нийт төмөр замын шугамын хэмжээнд 9 байрлалд суурийн ажил гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн 7 нь бүгд Гашуунсухайт өртөөнд байрлалтай, 2 нь өртөөнөөс гадна байрлана. Салхи ихтэй элсэрхэг газарт далан байгуулах, сул хөрстэй газарт ухмалын ажил байна. Төмөр замын трассын нийт урт нь 11.47 км, үүнд салхи ихтэй элсэрхэг газрын даланд 7 нэгж, 10.43 км байна

Далангийн төлөвлөлт. Үндсэн талбайн дээд хэсэг нь гурвалжин хэлбэртэй бөгөөд далангийн тэнхлэгээс хоёр тийш ус зайлуулах 40% налуутай байхаар төлөвлөсөн. Тахир өргөсөхөд үндсэн талбайн дээд гадаргуу нь гурвалжин хэлбэрээ хадгалсан байна. Далангийн үндсэн талбайн хамгаалалтын давхарга төсөллөх ба хамгаалалтын давхаргын доод давхаргад далангийн тэнхлэгээс хоёр тийш ус зайлуулах 40% налуу хэлбэртэйгээр төлөвлөнө гэж ТЭЗҮ-д дурдсан байна. Шулуун хэсгийн далангийн үндсэн талбайн өргөн: нэг замтай далангийн үндсэн талбайн өргөн нь 7.6м байна. Гүүрийн захаас 10м-ийн зайд доод бүтцийн гадаргуугийн өргөнийг хоёр тал руугаа 0.5м-ээр өргөтгөж, дараагийн 25м уртад далангийн өргөсөлтийг алгуур багасгах замаар ердийн өргөнтэй байхаар төлөвлөнө гэж ТЭЗҮ-д дурдсан байна.

1.3 Төслийн дэд бүтэц, түүхий эд материалын хангамж.

1.3.1 Усан хангамжийн эх үүсвэр. Төслийн барилга, бүтээн байгуулалтын ажлын үеийн усны хэрэглээг “Таван толгой төмөр зам” ХХК-ийн эзэмшлийн дараах худгуудаас хангах мөн шинээр гүний худаг гаргуулан ашиглахаар төлөвлөсөн байна. /Гүний худгийн паспорт, цооног өрөмдөх зөвшөөрлийг хавсаргав/

Зураг 3. Төлөвлөж буй худгуудийн байршил

Төслийн усны хэрэгцээ. Төслийн ТЭЗҮ-д дурдсанаар Барилга угсралтын ажлыг 2 жилийн хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Барилга угсралтын ажлын үед өдөрт 1900 орчим хүн ажиллах бөгөөд барилгын ажилд 448 хоног зарцуулна гэж үзэж байгаа юм байна. Төслийн хугацаа 2 жил байх боловч өвлийн улиралд барилгын ажил завсарлах тул тэр хугацааг хасаж тооцжээ. Үүнээс үзэхэд барилгын ажил хийгдэж байх үед хоногт хэрэглэх усны нийт хэмжээ $350000 \text{ м}^3 : 448 \text{ хоног} = 781.25 \text{ м}^3 / \text{хоног}$ буюу 9.04 л/с болж байна. Үүнээс унд, ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ барилгын ажлын үед 1 хүн хоногт 100 л ус хэрэглэнэ гэж үзвэл $190.0 \text{ м}^3 / \text{хоног}$ буюу 2.2 л/с болох юм. Технологийн усны хэрэглээ $1439.5 \text{ м}^3 / \text{хоног}$ буюу 16.6 л/с болж байна.

Барилга угсралтын ажил дууссаны дараагаар Гашуунсухайт боомтын ашиглалтын үйл ажиллагаанд зориулагдах усны хэрэглээ нь БНХАУ-ын стандартын дагуу хоногт 71.76 м³ буюу 0.8 л/с болно гэж тооцжээ.

Боомтод ажиллах хүний тоо 131 байна. Нэг хүн хоногт 200 л ус унд, ахуйн зориулалтаар ашиглана гэж тооцоход хоногт унд, ахуйн усны хэрэглээ 26.0 м³ /хоног буюу 0.3 л/с болох ба технологийн усны хэрэглээ нь $71.76 - 26.6 = 45.16$ м³ /хоног буюу 0.5 л/с байна.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг БНХАУ-ын Ганц мод Ваншүйчоань чиглэлийн төмөр замтай холбох бүтээн байгуулалтад шаардагдах усны хэрэгцээг доор хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 2. Нэг хоногт шаардагдах төслийн усны хэрэгцээ

д/д	Ус хэрэглэгч	Усны хэрэглээ м ³ /хоног (л/с)			Ажиллах хоног
		Унд ахуй	Технологи	Нийт	
1	Барилга угсралтын ажил	190.0 (2.2)	591.25 (6.84)	781.25 (9.04)	448
2	Гашуунсухайт боомт	26.0 (0.3)	45.16 (0.52)	71.16 (0.82)	Байнга


1.3.2 Цахилгаан хангамж.

Гашуунсухайт өртөө нь Цогтцэций 220/110/35 станцаас 35 кВ-ын 2 хэлхээ агаарын шугамаар Манхан 35 кВ-ын хуваарилах байгууламжаар дамжуулан авсан 35/10 кВ-ын 2х1250 кВА чадалтай дэд станц байрлах бөгөөд 10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн 1,2-р секцээс кабель шугамаар тус төслийг цахилгаанаар хангана. Энэ төсөлд шаардагдах гадна цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Гашуунсухайт өртөөний 2х1250/35/10 дэд станцыг Таван толгой станцад буй 2х2000/35/10 трансформатороор өргөтгөн 10 кВ-ын хуваарилах байгууламжийн 1,2-р секцээс 2 ячейк авч кабель шугамаар төслийн ачааллын төвд байршуулах трансформаторын дэд станц ТП-9-ийн 10 кВ-ын хуваарилах байгууламжинд холбон дотоод хуваарилалтыг зохион байгуулна.

1.3.3 Зам барилгын материалын хангамж. Карьер төлөвлөж буй төмөр замын зурвасд ойр байрлах чулуу ба хайрган материалд ашиглаж болохоор нийт 1 карьерыг ТЭЗҮ-д сонгож ашиглахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Далангийн материалд ашиглах карьерийн байршил

№	Өргөрөг	Уртраг	Талбайн хэмжээ .га
1	42° 30' 43.602"	107° 30' 17.063"	80.0513
2	42° 30' 55.343"	107° 29' 48.945"	
3	42° 30' 22.590"	107° 29' 25.462"	
4	42° 30' 16.720"	107° 30' 2.232"	
5	42° 30' 43.602"	107° 30' 17.063"	



Зураг 4. Далангийн материалд ашиглах карьерийн байршил

1.4 Төслийн үе шатны гүйцэтгэлийн талаарх товч танилцуулга

Ажиллах хүчин: Төслийн талбайд нийт 220 хүн ажилж байгаа бөгөөд үүнд ахлах инжнер 1, геодезийн инженер 2, жолооч 2, гүүр хоолойн инженер 1, Замын инженер 1, материалын инженер 2, зургийн инженер 1, инженер техникийн ажилчид 29, ажилчид 80 тус тус байна.

Машин механизм: Нийт 53 машин механизмтай ажиллаж байгаа бөгөөд үүнд үйлчилгээний 2ш, усны машин 2 ш, миксер 3ш, ачигч 2 ш, 4тн кран 1 ш, түлшний машин 1 ш, экскаватор 10 ш, ковш 8 ш тус тус байна.

Ажил гүйцэтгэл: Үндсэн 7 багц ажлын 1, 2 дугаар ажил буюу төмөр замын доод, дээд бүтэц, эстакадан гүүрийн ажлууд хийгдэж байна. Мөн бусад бэлтгэл ажлууд болох пүүний барилга угсралтын ажил, хаалттай бүсийн хашаа угсрах, ажилчдын кемп байгуулах, оффисын хэсэг, арматур бэлтгэх хэсэг, материал агуулах хэсэг, бетон хольцын үйлдвэр угсрах ажилууд хийгдсэн байна.

Хүснэгт 4. Бүтээн байгуулалтын ажлын хэмжээ, гүйцэтгэлийн хувь

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Нийт төлөвлөсөн тоо	Гүйцэтгэлийн тоо хэмжээ	Нийт ажлын гүйцэтгэл	
					Нийт гүйцэтгэл	Хувиар
Багц 1. Төмөр замын доод, дээд бүтэц						
1	Дугуй хоолойн суурийн ухмал	м ³	11342.68	7672.06	7672.06	67.63%
2	Дөрвөлжин хоолойн суурийн ухмал	м ³	37361.09	5337.14	5337.14	14.28%
Багц 2. Эстакадан гүүр						
1	Шон суурь	ширхэг	2376	-	114	4.8%
2	Тулгуурын хөндлөн нуруу	ширхэг	291	-	3	1,03%
3	Тулгуурын их бие	ширхэг	291	-	1	0.34%
Бусад бэлтгэл ажил						
1	Ажилчдын кемп байгуулах	блок	192	112	160	83.3%
2	Оффисын хэсэг	өрөө	94	24	24	25.53%
3	Арматур бэлтгэх хэсэг	м ²	2400	996	1956	81.5%
4	Материал агуулах хэсэг	м ²	6750	2580	2793	41.38%
5	Бетон хольцын үйлдвэр	ш	2	1.22	1.22	61%



Зураг 5. Ашиглалтанд орсон ажилдын сууцны харагдах байдал./2025.10.18/



Зураг 6. Ажилчдын түр кемтийн ажлын явц/2025.10.18/




Зураг 7. Бетон хольцийн үйлдвэр угсралтын ажил./2025.10.18/



Зураг 8. Барилгын материалын бэлдэцийн үйлдвэрийн барилгын ажлын явц/2025.10.18/



Зураг 9. Бетон дүүргэгч материалын агуулахын суурь барилгын ажлын явц/2025.10.18/



Зураг 10. Технологийн замын ажлын явц/2025.10.18/



Зураг 11. Төмөр замын доод бүтцийн дугуй болон дөрвөлжин хоолойн суурийн ухмал

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.

Хүрээлэн буй орчинд үзүүлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжүүлсэн ажил	Тайлбар
1. АГААРЫН ЧАНАР				
Тоосжилт үүсэх, утаа болон хийн бохирдол үүсэх	Техник хэрэгслийг үзлэг оношлогоо, засвар үйлчилгээг тогтмол хийж, стандарт шаардлагад нийцүүлэх	Төслийн талбайд нийт 53 техник хэрэгсэл ажилж байгаа бөгөөд өдөр бүр ажилд гархын өмнө эвдрэл гэмтлийг ХАБА хянаж гаргадаг.	Техник хэрэгслүүдийг бүрэн бүтэн, эвдрэл гэмтэлгүйгээр ажлын талбайд гаргадаг бөгөөд бүртгэлийг тогтмол хөтлөн ажилж байна. Хавсралт матрица 1. Механик тоног төхөөрөмжийн бүртгэлийн хуудас.	Техник хэрэгсэл бүгд шинээр ашиглагдаж байгаа.
	Төслийн талбайд технологийн замыг бий болгох, тоосжилт үүсэх зам, талбайг сайжруулах, бетонон хучилт хийх	Ажилчдын кемп болон бетон зуурмагийн талбай, авто зогсоол зэрэг техник зорчих хэсгийг бүрэн хатуу хучилттай болгоод байна.	Ажилчдын кемп, бетон зуурмагийн талбайн хэсэг болон авто зогсоолын талбайг бүрэн хатуу хучилттай болгосон Хавсралт зураг 1.	Цаашид технологийн замын трасс, хөндлөн огтлол, тоо хэмжээ зэргийг яаралтай гаргаж, трассыг орон нутгийн холбогдох газарт танилцуулж, зөвшөөрөл авахаар ажиллаж байгаа.
2. ГҮНИЙ УС				

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт хэрэгжиж буй “Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох” төслийн 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”

Усны нөөц багасах, түвшин буурах, усан орчин бохирдох	Усны эх үүсвэрүүдийг тоолууржуулах, эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалалтын байр барих, усан орчинд бохирдол үүсгэхгүй байхаар бүрэн тоноглож, битүүмжлэх.	Төслийн талбайд нийт 4 худаг байгаа бөгөөд 3 худаг нөөцөд 1 худгийг бүрэн тоноглож ашиглаж байна	Ашиглаж буй худгийг тоолууржуулж, эрүүл ахуйн бүс тогтоож хамгаалалтын байр барьсан, усан орчинд гадны бохирдол үүсэхээс сэргийлж бүрэн тоноглож битүүмжилсэн Хавсралт зураг 2. Мөн хуулийн дагуу ус ашиглах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулан ажилж байна. Хавсралт материал 2.	Төслийн бэлтгэл ажил хийгдэж байгаа бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажиллах үед нөөцөд байгаа худгуудыг тоноглож ашиглана.
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ				
Хөрсний үржил шим алдагдах Хөрсний элэгдэл, эвдрэл бий болж ургамлан нөмрөг устгах,	Төслийн ажлын явцад түр замын маршрутыг тогтоож, олон салаа зам үүсгэхгүй байх, тэмдэгжүүлэх	түр зам, ус, эрчим хүчний түр байгууламж, бетон зуурмагийн үйлдвэр, дам нуруу, дам нурууны агуулах, талбайгаас цааш дам нуруу тээвэрлэх зам, том гүүрний кран гүйлтийн зам, дүүргэгч материал хадгалах талбай, түр тулгуур байгууламж, дам нуруу босгох машинд зориулсан дам нуруу тээвэрлэх түр замыг барина.	Технологийн түр замын чиглэл гарган олон салаа шороон зам үүсгэхгүй байхаар анхааруулах зөвлөмжтэйгээр ажиллаж байна. Хавсралт зураг 3.	Цаашид технологийн замын трасс, хөндлөн огтлол, тоо хэмжээ зэргийг яаралтай гаргаж, трассыг орон нутгийн холбогдох газарт танилцуулж, зөвшөөрөл авахаар ажиллаж байгаа.
	Үржилт шимт хөрсийг хуулж хадгалах,	Барилгын ажлын талбай /карьер, төмөр замын трасс, барилга, түр зам/	Карьерийн талбай болон бусад барилгын ажлын талбайд үржилт шимт хөрсийг хуулж хадгалж байна /Хавсралт зураг 4/.	-

2.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Энэ оны төлөвлөгөөнд тусгагдаагүй тул хийгдэхгүй.

2.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдаагүй.

2.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс шалтгаалан болзошгүй осол, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл гарах, үйл ажиллагаа доголдох, зогсох,	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг мэргэжлийн байгууллагас авч үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Цаг агаарын урьдчилсан мэдээг 5 болон 7 хоногийн давтамжтай авч, цаг агаарын аюулт үзэгдэлтэй үед ажилыг бүрэн зогсоож, ХАБ-н ажилтны удирдлага дор ажилладаг /Хавсралт зураг 5/.
Болзошгүй осол, техник, тоног төхөөрөмжийн гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангах	Сургалтын арга хэмжээг тогтмол хэрэгжүүлдэг /Хавсралт зураг 6./ Ажилчдын кемп болон бусад шаардлагатай объект техникд галын хор, аюулгүй байдлын санамж анхааруулах тэмдгэлтгээг байршуулж ажиллаж байна. /Хавсралт зураг 7/.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт хэрэгжиж буй “Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох” төслийн 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”

2.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлсэн
Ахуйн хатуу хог хаягдлыг хадгалах түр цэг байгуулах	Ангилан хаях зориулалттай хогийн савыг кемп дээр байрлуулах	Байршуулсан
Хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдал ангилан хаях түр хадгалах пункер байрлуулах Дахин ашиглагдах (шил, лааз, хуванцар, төмөр, мод, цаас) Ханбогд сумын түүхий эд авах цэгт нийлүүлэх	Ангилан ялгаж түр хадгалан давихар авах цэгт нийлүүлсэн
Ахуйн хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт нийлүүлэх (тээвэрлэх)	хаягдлыг хог хаягдал тээвэрлэх эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлнэ. Шаардлагатай тохиолдолд тухай бүр	Ахуйн хог хаягдлаа хогийн цэгт тээвэрлэж хаядаг
Бие засах газрыг сайжруулсан нүхэн жорлон барих эсвэл бага оврын цэвэрлэх байгууламж барих	Ажилчдын байр болон оффиссын байрнуудыг харгалзан үзэж нэгдсэн нэг нойл, ариун цэврийн байгууламжийг шийдэх бөгөөд бага оврын цэвэрлэх байгууламж эсвэл септик танкинд хуримтлуулан цэвэрлэх байгууламжруу зөөвөрлөж байхаар шийднэ.	Бэлтгэл ажил буюу газар шорооны ажил хийгдэж байна /Хавсралт зураг 8/.
Шатах тослох материалын хаягдал зориулалтын саванд цуглуулж, хадгалах	Шатах тослох материалын үлдэгдлийг зориулалтын саванд цуглуулж хадгалах, зохих байгууллагад нийлүүлэх.	Аюултай хог хаягдлыг стандартын дагуу тусгай цементлэсэн талбайд байрлуулж цуглуулж, зохих байгууллагад нийлүүлэхээр ажиллаж байна.
Аюултай хог хаягдлын тайлан мэдээ гаргах	технологид ашиглаж буй химийн бодисын сав баглаа боодол, үлдэгдлийг Хог хаягдлын тухай хуулийн 22, 23дугаар зүйлд заасны дагуу бүртгэл хөтөлж устгалд хамруулах.	Өмнөговь аймгийн байгаль орчны газарт хандаж аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлсэн. /Хавсралт материал 3/. Аюултай хог хаягдлын талаар сургалт зохион байгуулсан /Хавсралт материал 4/.

2.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлсэн	Тайлбар
1. АГААРЫН ЧАНАР			
SO ₂ , CO ₂ , NO ₂ , утааны хэм 0C, утааны агаарын даралт, утааны хурд м/с	Агаар 1. 42°25'22.52 107°34'41.99" Агаар 2. 42°26'33.98 107°32'35.23" Агаар 3. 42°25'22.3 107°34'41.8"	Хээрийн судалгааны үед авсан дээжийг цаг уур, орчны шинжилгээний газар, байгаль орчин хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлэн гарсан дүнг Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 –тай харьцуулахад давсан үзүүлэлт байхгүй буюу хүлцэх хэмжээнд байна. Хээрийн хэмжилтийг /хавсралт зураг 9/-оруулав, лабораторийн дүн эх хувиар хавсаргав.	
Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5} , тоосны чөлөөт уналт, тоосны найрлага, бүтэц, тархалт			
2. УСНЫ ЧАНАР			
Усны ерөнхий шинжилгээ (амт, үнэр, өнгө, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин)	Зээрд № 1 -худаг. 42°29'55.07" 107°26'52.3"	Энэхүү худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлорын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн чанарын хувьд цэнгэгдүү харьцангуй ихэвтр эрдэсжилттэй, зөөлөн ус байна. лабораторийн дүн эх хувиар хавсаргав.	
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ			
Хөрсний хими, механик бүрэлдэхүүн, хүнд металл, эрүүл ахуй: pH, давс, цахилгаан дамжуулах чанар, ялмаг, карбонат, шингээгдсэн сууриуд Ca, Mg, шим тэжээлийн элементүүд P ₂ O ₅ , K ₂ O, ширхэгийн бүрэлдэхүүн, Эрүүл ахуй, Хүнд металл- Ni, Cd,Pb,Cu,Zn, Cr	Хөрс 1. 42°28'64" 107°30'55.9" Хөрс 2. 42°27'29.18" 107°30'55.9" Хөрс 3. 42°26'09" 107°32'13.97" Хөрс 4. 42°26'08.25" 107°33'05.11" Хөрс 5. 42°29'49.2" 107°26'52.3	<ul style="list-style-type: none"> ➤ Төслийн талбайд нийт 5 цэгт хөрсний дээж авч агрохими, хүнд металлыг шинжлүүлэв. Хөрсний дээж авсан фотог /хавсралт зураг 10/, лабораторийн дүн эх хувиар хавсаргав. ➤ Шинжилсэн дүнгээр хөрс нь дунд-хүчтэй шүлтлэг урвалын орчинтой, ялмагийн агууламж бага, давсжилтгүй карбонатлаг, элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй хөнгөн хөрс байна. Хөрсөнд агуулагдах зарим хүнд металлын шинжилгээгээр “хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай MNS 5850:2019/-тай харьцуулахад хүлцэх хэмжээнд буюу бохирдолгүй байна. ➤ БОМТ-ний орон нутгийн санд төвлөрүүлж ажилласан. /хавсралт зураг 4/ 	
4.УРГАМЛАН НӨМРӨГ			
Ургамлын зүйлийн бүрдэл, Бодгалийн тоо, дундаж өндөр, Бүрхэц	Ургамал 1. 42°26'39.77" 107°31'27.7 Ургамал 2. 42°25'05.893"	Ургамлын мониторинг судалгааг ургамал ургалтын үед буюу 7 сард хийж зүйлийн бүрдэл, тусгаг бүрхэц, арвийн зэрэг болон ашигт зүйлээр нь ангилан бичив.	

Судалгааны цэг -1



Зураг12. Нэг наст бүхий сөөгт бүлгэмдэл

Тус талбай нь ус урсах өргөн сайрын захаар тархах бөгөөд нэг наст бүхий сөөгт бүлгэмдэл, тусгагийн бүрхэц 25%, 13 зүйлийн ургамал (бичиглэл-1) бүртгэгдсэн, ургац 3,5 ц/га байсан. Ургамлан нөмрөгийн өндөр 35 см бөгөөд сөөгний том сондуул элс хунгарласан довцогтой. Талбайд 1,5 метр өндөртэй хайлаас ургана. Зонхилогч ургамлын хувьд алаг өвснөөс Алтан бэрмэг, Нарийн Бэрээмэг, Харлаг Үмхий-өвс, үетнээс Гялгар Дэрс, цөөн наст ургамлаас Ямаан Шарилж, Манан хамхаг ургана. Сөөгнөөс Шинэсэрхүү Бударгана (загсагал), Регелийн шар модлог, Зүүнгарын Бударгана (улаан бударгана), Сөөгөн зогдоргоно, Одой Хайлаас, Төв Азийн Лавай ургана. Бэлчээрийн талхагдал бага байсан. Хур тунадас их орсонтой холбоотой зүйлийн олон янз байдал, нэг настын синзи ихээр нэмэгдсэн байсан.

Хүснэгт 9. Ургамлын зүйлийн бүрдэл./ Бичиглэл 1./

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц, %	ангилаа	Ашигт ургамал
1	Salsola laricifolia	Шинэсэрхүү Бударгана	1ш	sol	гоц ашигт ургамал
2	Sympegma regelii	Регелийн шар модлог	1ш	sol	бэлчээр
3	Reaumuria soongorica	Зүүнгарын Бударгана	1ш	sol	үлдэц ургамал
4	Clematis fruticosa	Сөөгөн зогдоргоно	1ш	sol	бэлчээр
5	Ulmus pumila L.	Одой Хайлаас	1ш	sol	мод
6	Limonium aureum	Алтан бэрмэг		sol	нэн ховор ургамал
7	Achnatherum splendens	Гялгар Дэрс		sol	бэлчээр
8	Limonium tenellum .	Нарийн Бэрээмэг		sol	бэлчээр
9	Asterothamnus centrali-asiaticus N	Төв Азийн Лавай		sol	завсрын унаган, нэн ховор ургамал
10	Bassia dasyphylla	Дэрэвгэр Махан хамхаг		sol	олшрогч ургамал
11	Peganium nigellastrum	Харлаг Үмхий-өвс		sol	олшрогч ургамал
12	Bassia dasyphylla	Дэрэвгэр Махан хамхаг		sol	олшрогч ургамал
13	Artemisia scoparia	Ямаан Шарилж	20	sp	олшрогч ургамал

Судалгааны цэг -2



Зураг 13. 2-р бичиглэл хийсэн цэгийн ерөнхий ургамалжил, 1м² талбай дахь ургамалжил

Тус талбай нь тэгш хөндийгөөр тархах цөлийн сөөгт бүлгэмдэл бөгөөд тусгагийн бүрхэц 43%, халцгай газар 57%, 14 зүйлийн ургамал бүртгэгдсэн, 100м.кв. талбайд 11 зүйл ургана, ургац 3,1 ц/га байсан. Талбайд үетэн ургамлаас сайрын хялгана, алаг өвснөөс хөмөл, намхан бажууна, толбот бэрмэг, сөөг ургамлаас хулан хойрго, бор бударгана, зүүнгарын улаан бударган, ахар навчит баглуур ургана. 2025 онд хур тунадас их орсонтой холбоотойгоор талбайн зүйлийн олон янз байдлаар баялаг, ургац арвин байна. Цөлд хур тунадас орсноор Толгодын Бударгана -1%, баг хуш хамхаг- 1%, Услиг Манан- хамхаг -1%, оготны сүүл -1%, ямаан шарилж 20% бүрхэц үүсгэн дүүргэж ургаж байна. Бэлчээрийн талхагдал бага байна.

Хүснэгт 10. Ургамлын зүйлийн бүрдэл Бичиглэл-2

Ургамлын зүйлийн бүрдэл					
№	Ургамлын латин нэр	Ургамлын монгол нэр	Бүрхэц (%)	Арви	Ашигт ургамал
1	<i>Potania mongolica Maxim</i>	Хулан Хойрго	4	Sp	Нэн ховор /у
2	<i>Arnebia guttata Bge.</i>	Толбот Бэрээмэг	1	Sp	Нэн ховор /у
3	<i>Bassia dasyphylla (Ficsh. et Mey.) Ktze.</i>	Услиг Манан- хамхаг	1	Sp	олшрогч ургамал
4	<i>Salsola passerna Nels.</i>	Өргөст Бударгана	1	Sp	Бэлчээр
5	<i>Allium mongolicum Rgl.</i>	Хөмөл Сонгино	1	Sp	Элбэг /а
6	<i>Reaumuria soongorica (Pall.) Maxim.</i>	Зүүнгарын Бутаргана	1	Sp	Элбэг /а
7	<i>Enneapogon boreals</i>	Умардын оготны сүүл	1	Sp	олшрогч ургамал
8	<i>Eragrostis minor Host.</i>	Бага Хургалж	10	Сор1	Элбэг /а
9	<i>Anabasis brevifolia C.A.Mey</i>	Ахар навчит Баглуур	1	Sp	Бэлчээр
10	<i>Halogeton glomeratus</i>	Баг хуш хамхаг	1	Sp	олшрогч ургамал
11	<i>Salsola collina Pall.</i>	Толгодын Бударгана	1	Sp	Элбэг /а
12	<i>Stipa glareosa P.Smirn.</i>	Сайрын Хялгана		Sol	Элбэг /а
13	<i>Rheum nanum Sievers.</i>	Намхан Гишүүнэ		Sol	Элбэг /а
14	<i>Artemisia scoparia</i>	Ямаан Шарилж	20	sp	олшрогч ургамал

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт хэрэгжиж буй “Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох” төслийн 2025 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан”

2.7 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 11 . Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт


№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэрэгжүүлсэн
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж ажилласан /Хавсралт зураг 5, 6/
2	Байгаль орчны хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, орон нутгийн байгаль орчны албатай харилцан холбоотой ажиллах		Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас өгсөн чиг үүргийг гүйцэтгэн, шаардлагыг биелүүлэн ажилж байна.
3	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Гэрээт байгууллагаар хийлгэх	Хоёрдугаар төв эмнэлэгт ажилчдыг эрүүл мэндийн үзлэг оншилгоонд хамруулсан /Хавсралт материал 5/.

2.8 Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 12 . Оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Хэрэгжүүлсэн тухай
Багийн иргэдийн нийтийн хурал Аймгийн Байгаль орчны газар	Уулзалт, хэлэлцүүлэг, албан бичиг Тухайн жилийн БОМТ-г дүгнүүлэх, биелэлтийн тайлан хүргүүлэх	Хэрэгжүүлсэн Тайланг хүргүүлж байна
БОУАӨЯ-нд БОМТ биелэлтийн тайланг хүргүүлж хянуулна	Тухайн жилийн БОМТ-г дүгнүүлэн, биелэлтийн тайланг илгээж хянуулах	БОМТ-ний биелэлтийн тайланг илгээх ажил явагдаж байна.

Хавсралт зураг 1. Зам талбайн тоосжилтыг бууруулах арга хэмжээний хэрэгжилт




Бетон зуурмагийн талбайн хатуу хучилттай газар



Кемп орчмын хатуу хучилттай газар

Хавсралт зураг 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ



Зээрд 10 Худгийн эрүүл ахуйн хамгаалалтын байр (гадна, дотор)



Зээрд 10 Худгийг тоолууржуулсан байдал

Хавсралт зураг 2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ



Хавсралт зураг 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ



2025-11-12 09:21:06

N 42° 26' 11", E 107° 34' 35"

Төслийн нэр: Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төсөл

Байршил: Түгээмэл тархацтай ашигт малтмалын талбай

Ажлын нэр: Тоосжилт дарах талбайн усалгаа

Хавсралт зураг 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
Хөрсөн бүрхэвч ургамлан нөмрөгийг хамгаалах арга хэмжээ, олон салаа шороон зам үүсгэхгүй байж чиглэллийн дагуу технологийн зам ашиглаж буй байдал.



Зураг 10. Технологийн замын ажлын явц/2025.10.18/

Төслийн бүтээн байгуулалтын үед технологийн түр замыг тавьж ашиглаж байна

Хавсралт зураг 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ




Хавсралт зураг 4. Үржил шимт хөрс хуулалт хадгалалт

Хөрсөн бүрхэвчийг хамгаалах арга хэмжээ буюу үржил шимт хөрсийг хуулж стандартын дагуу овоолго үүсгэн хадгалж байна.



Усны хоолой ухмал, үржил шимт хөрсний овоолгын харагдах байдал. 2025.10.18



Карьерийн үр шимт хөрсний овоолгын харагдах байдал. 2025.10.18

Хавсралт зураг 4. Үржил шимт хөрс хуулалт хадгалалт



Хавсралт зураг 5. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа, санамж анхааруулга




ХАБЭА-н зааварчилгаа

Хавсралт зураг 6. Техник, технологийн хяналтын инженерүүд ХАБЭА-н сургалт



Техник, технологийн хяналтын инженерүүд ХАБЭА-н сургалт

Хавсралт зураг 7. Гал унтраах хор ажилчдын байранд байршуулсан



Хавсралт зураг 5. Аюултай болон ахуйн хог хаягдлын ачилтын бүртгэл

Ахуйн хог хаягдал татав аялтын бүртгэл
Байгуулагчийн нэр

№	Огноо	Хогны хэмжээ/Хогийн сав	Монгол дун	Гарын үсэг
1	2016.03.02	1115		
2	2016.03.03	8115		

Хүтээн авсан: *Б. Батбаяр*

№	Огноо	Хогны хэмжээ/Хогийн сав	Монгол дун	Гарын үсэг
1	2016.03.03	8115		

Хүтээн авсан: *Мөнхтүвшин*

№	Огноо	Хогны хэмжээ/Хогийн сав	Монгол дун	Гарын үсэг

Хүтээн авсан: _____

№	Огноо	Хогны хэмжээ/Хогийн сав	Монгол дун	Гарын үсэг

Хүтээн авсан: _____

№	Огноо	Хогны хэмжээ/Хогийн сав	Монгол дун	Гарын үсэг

Хүтээн авсан: _____

Хог ачилтын жагсаалт
废弃物（垃圾）运输清单

№ 序号	Огноо 日期	Автомашин дугаар 汽车牌照号	Хог хаягдлын хэмжээ/н 废弃物量/件	Ажилт хийсэн ажилчийн гарын үсэг 驾驶员姓名	Ажилт хийлгэсэн ажилчны гарын үсэг 收货人姓名
1	2021.12.18	9125	17	<i>Хонгор</i>	<i>Хонгор</i>
2	2021.1.16	9125	17	<i>Хонгор</i>	<i>Хонгор</i>
3	2016.02.28	9125	15	<i>Б.Батбаяр</i>	<i>Хонгор</i>
4	2016.03.28	3452	17	<i>Б.Батбаяр</i>	<i>Хонгор</i>
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					

Хавсралт зураг 8. Бохир ус хуримтлуулах юмкостын газар дээрх тагны битүүлэл



Хавсралт зураг 9. Агаарын чанарын хэмжилт, дээжлэлтийн явц



Агаарын чанарын хэмжилт, 1-р цэг дээр



Агаарын чанарын хэмжилт, 2-р цэг



Агаарын хэмжилт 3-р цэг

Хавсралт зураг 10. Хөрсөн бүрхэвчийн хэмжилт, дээжлэлтийн явц



Хавсралт зураг 4. БОМТ-ний хэрэгжилтийн урьдчилгаа төлбөр



Online transaction receipt

Request Reference Number: S81611780202510144

Downloaded date: 2025-12-15 16:46

Sender account number	Receiver account number	Transaction amount	Status
8125103046 MN130015008125103046	MN650090100111055410	9,410,000.00 MNT	Successful
Sender name ХЯТАДЫН ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН КОРПОРАЦЫН ГҮҮРЭН БАРИЛГЫН ТОВЧОО	Receiver name ӨМ.ХАНБОГД БАРЬЦАА	Remarks CHINA ӨМ.ХАНБОГД БАРЬЦАА,ӨМ.ХАНБОГД БАРЬЦАА,То	
	Receiver bank Төрийн сан	Transaction date 2025-10-14	



Хавсралт зураг II.Сум болон багийн иргэдийн нийтийн хуралд хэрэгжилтийг тайлагнав.



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК

14230 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Нарны зам 62, Юмюн Бюлдиг Б блок, 11 дугаар давхар

Утас: 7777 7727, 7777 7877

И-мэйл: info@ttz.mn, Вэбсайт: www.ttz.mn

2025.10.24 № 01/1242

талай _____ -ны № _____ -т

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ**

Тайлан хүргүүлэх тухай

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа "Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох төсөл"-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2024 онд Байгаль орчин, аялал жуулчлалын ямаар батлуулж, төслийн үйл ажиллагаа 2025 оны III улиралд эхлэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төслийн бэлтгэл ажлын хүрээнд бүтээн байгуулалтын хаалттай бүсийн хашааг барьж, ажилчдын түр кемп болон оффисын барилга, бетон зуурмагийн үйлдвэр барих, түр зам байгуулах зэрэг ажлууд хийгдэж байгаа бөгөөд байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлээ.

Тайланг 3 хувь хүргүүлэв.

Хавсралт/XX хуудастай.







ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ПҮРЭВЖАРГАЛ

Хавсралт материал 1.Техник тоног төхөөрөмжийн бүртгэлийн жагсаалт

机械设备统计表
Механик тоног төхөөрөмжийн бүртгэлийн хүснэгт

序号 №	设备名称 Тоног төхөөрөмжийн нэр	规格 Тодорхойлолт	车牌号	单位 нэгж	数量 Тоо ширхэг	备注 Тайлбар
1	翻斗车 sonsmol	北奔 Bei Ben North Benz	5084 УВХ	台 ширхэг	1	
2	翻斗车 sonsmol	北奔 Bei Ben North Benz	6451 УБС	台 ширхэг	1	
3	翻斗车 sonsmol	北奔 Bei Ben North Benz	7946 УНИ	台 ширхэг	1	
4	翻斗车 sonsmol	北奔 Bei Ben North Benz	5084 УВХ	台 ширхэг	1	
5	翻斗车 sonsmol	豪沃 Howo	8500 УКО	台 ширхэг	1	
6	小车 suudlin mashin	马自达 Mazda pameie	5709 YAO	台 ширхэг	1	

БҮРТГЭВ
15/10/2019 136

7	翻斗车 sonsmol	豪沃 Howo	2122 УНЗ	台 ширхэг	1	
	装载机 Kowsh	徐工 XU GONG	550	台 ширхэг	1	
	挖掘机 excevator	现代 HYUNDAI	300	台 ширхэг	1	

БҮРТЭВ
2017.09.20 138

Холбоо барих :
Нэмэлт мэдээлэл:

88012217

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
--------------------	------------------	-------------

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
---------------------	-------------------------------	------------------	--------------------------

10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт хүчингүй болохыг анхаарах;

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Төмөр замын барилга байгууламжийн далан байгуулах ажилд шаардлагатай усны хэмжээ	700000	м3	0.08	1.0	Удаа	56,000.00	0.00	56,000.00
Бетон зуурмагийн ажилд шаардлагатай усны хэмжээ	36300	м3	0.3	1.0	Удаа	10,890.00	0.00	10,890.00
Зам талбайн тоос дарах усалгаанд шаардлагатай усны хэмжээ	35000	м2	0.002	180.0	Удаа	12,600.00	0.00	12,600.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	800	хоногт 1 хүн	0.15	183.0	Хоног	21,960.00	0.00	21,960.00
Нийт						101,450.00	0.00	101,450.00

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Төмөр замын барилга	56000.00	Газрын	0.0	199.80	11,188,800.00	0.0	11,188,800.00

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
байгууламжийн далан байгуулах ажилд шаардлагатай усны хэмжээ		доорх ус					
Бетон зуурмагийн ажилд шаардлагатай усны хэмжээ	10890.00	Газрын	0.0	199.80	2,175,822.00	0.0	2,175,822.00
Зам талбайн тоос дарах үсалгаанд шаардлагатай усны хэмжээ	12600.00	Газрын	0.0	199.80	2,517,480.00	0.0	2,517,480.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	21960.00	Газрын	0.0	95.90	2,106,051.84	0.0	2,106,051.84
Нийт	101,450.00				17,988,153.84		17,988,153.84

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Ахуйн бохир усыг зохих стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, халдваргүйжүүлэн зам, талбайн тоосжилт, биологийн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Ус ашиглуулах дүгнэлтийн онцгой нөхцөлийг хангаж ажиллаагүй тохиолдолд дараа оны ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй болохыг анхаарч ажилдлана үү;
- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Галба-Өөш долоодын говийн сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
